БАТЛАВ.
МИАТ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Б.МӨНХТАМИР

2025 оны 02 сарын 04-ны өдөр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Агаарын хөлгийн чирэгч трактор /Towing Tractor/

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт
1.	Агаарын хөлгийн чирэгч трактор /Towing Tractor/	1	**Ерөнхий шаардлага** Уг трактор нь нарийн болон өргөн биетэй агаарын хөлгийг чирэх холбоос ашиглан чирэх, түрэх зориулалттай бөгөөд ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ явуулахад хялбар байхын дээр цахилгаан болон гидравлик тоноглол нь хамгийн сүүлийн үеийн технологи ашиглан хийгдсэн байна. Трактор нь агаарын хөлөгт үйлчлэх үед аль болох хялбар удирдлагатай, аюулгүй байдлыг урьдчилан хангах боломжтой. Манай орны цаг агаар эрс тэс, агаарын хэм нь өвөлдөө - 45°C, зундаа + 40°C хүрч огцом өөрчлөгддөг тул трактор, тоноглолын эд ангиуд дээрх цаг агаарын нөхцөлд тохирсон байх шаардлагатай. Мөн дээрх трактор нь манайтай цаг агаар ойролцоо орны нисэх буудлуудад нийлүүлэгдэж, тэнд ашиглагдаж байгаа нь тодорхойлогдсон байна. TMX-350-28 эсвэл түүнтэй дүйцэх загварын трактор нь A350 болон B787 хүртэлх 300 тн жин бүхий бүх төрлийн агаарын хөлөгт үйлчлэх хүчин чадалтай, европын стандарт, найдвартай ажиллагааны шаардлагыг хангасан шинэ чирэгч трактор байна. **Стандарт шаардлага:** – ISO 7717 EN 12312-7, ISO 6966-1, 6966-2, EN1915-1, – SAE ARP 1558, SAE AIR 1363, SAE ARP 1247, – IATA AHM 601 910, 913, 914, 915, 955 стандартын шаардлагуудыг хангасан байна. **Ерөнхий үзүүлэлтүүд** **Тусгай тоноглол:**

			Трактор нь агаарын хөлгийг чирэх болон түрэх зориулалтаар урд болон хойд талд 70 мм буюу 2,75 инчийн пальц бүхий чирэх хэрэгслээр тоноглогдсон байна. Шулуун татах хүч 210 KN буюу (47200 lbf) ба түүнээс дээш байх Нийт жин 28000 кг буюу (46300 lbs) ба түүнээс дээш байх **Хөдөлгүүр:** Cummins QSB4.5 маркийн 2500 эрг/минутад 129 Kw хүчин чадлыг гаргах 4 цилиндр бүхий турбо дизель хөдөлгүүрээр тоноглогдсон байх ба хөдөлгүүр хэт халах, хөргөлтийн шингэн багасах, тосны түвшин багасалт, шатахуун хэт багассан үед мэдэрч хөдөлгүүрийг автоматаар унтраах ослын унтраалгатай байна. Тос, түлшний 2ш /нарийн болон тунгаагуур/, агаарын шүүрүүдээр тоноглогдсон байна. Хөдөлгүүрээс гарах утаа Евро III, IV стандартад нийцсэн байна. **Жолоо:** Жолоо нь шингэнт гидростатик системтэй байх бөгөөд бүх дугуй нь удирдагддаг байна. Жолооны аваарын гидросистемтэй байна **Хяналт хэмжүүрүүд:** – Тосны даралт хэмжигч – Температур хэмжигч – Батарейн гүйдэл хэмжигч – Мото/цагийн тоолуур – Хурд хэмжүүр – Хөдөлгүүрийн эргэлт тоологч – Жолооны дугуйн байрлал **Анхааруулах гэрэл** : – Тосны даралт уналт – Хөдөлгүүрийн хэт халалт – Батарей цэнэгээ алдсаныг – Гидрийн шингэний шүүрний бөглөрөл – Гар тормозтой – Их гэрэл ассан **Хурдны хайрцаг :** ZF4WG190 загварын эргэлтийн момент хувиргагч бүхий урагшаа 4 болон ухрах 3 байрлалын удирдлагатай автомат хурдны хайрцаг **Урд болон хойд тэнхлэг:** DANA загварын урд болон хойд тэнхлэг бүхий 4 дугуй хөтлөгчтэй, 4 дугуйн удирдлагатай. Дугуйн хэмжээ: 300/80-22,5 **Нэмэлт тоноглол:** • Тоноглол болон хөдөлгүүрийг унтраах ослын унтраалга

			• Ухрахын дуут дохио • Гэрэл, дохиогоор бүрэн тоноглогдсон • Үйл ажиллагааны бүх мэдээлэл бүхий өнгөт дэлгэц /хянах самбар/ • Анхааруулах маяк • Бүхээг дулаацуулах систем болон агааржуулагч • Урд болон арын хэсгийг харах камер • Төвийн тосолгооны системтэй • Урд шил арчигч • Өнгө Цагаан RAL 9016 • Жолоодлогын 3 тавилт буюу (2 front WS, 4WS, Crab) • Запаас дугуй 1 ш **Кабин тоноглол:** 2 хүний суудалтай жолоочийн тав тух, аюулгүй байдал үзэгдэх орчныг дээд зэргээр хангасан. Гидравлик гар тормоз болон үндсэн тормозны системээр тоноглогдсон. Трактерын үйл ажиллагааны бүх мэдээлэл бүхий өнгөт дэлгэц, урд шил арчигч угаагчийн хамт тоноглогдсон байна. **Цахилгаан тоноглол:** 24 вольтын тогтмол гүйдлийн цахилгааны систем, тог салгагч, 12 вольтын 2 ш аккумлятор, 120 амперын тогтмол гүйдлийн генератор тус тус тоноглогдсон байна. **Бусад нөхцөлүүд:** Трактерын ашиглалт, сүүлийн үеийн нэмэлт тоноглол болон засвар үйлчилгээний талаар үйлдвэрлэгч компаниас сургалтыг цахим болон танхимын боломжтой нөхцөлөөр зохион байгуулах Ашиглалтын гарын авлага болон техник үйлчилгээ засварын заавар, сэлбэгийн каталог зэргийг англи хэл дээр CD болон ном хэлбэрээр дагалдуулах Үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа 1 жил
	Жишээ зураг:  		

Боловсруулсан: ГТЗАТТҮТ-ийн дарга бөгөөд
Ерөнхий инженер

Д.Эрдэнэбилэг